

4

ДНБ-ий ТООЦООНЫ ЗӨРҮҮГ БАГАСГАХ

Ц.Цэрэндорж, Л.Мянганжаргал

1. Судлах шаардлага

Манай улс зах зээлийн эдийн засгийн харилцаанд шилжиж буй өнгөрсөн арав гаруй жилийн хугацаанд статистик бүртгэл, мэдээллийн тогтолцоо, түүний үзүүлэлтүүдийн систем, арга зүйд багагүй өөрчлөлт орлоо. Ялангуяа макро эдийн засгийн түвшний үзүүлэлтүүд, тэдгээрийг тооцох аргачлал тухайлбал, төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засгийн үндэсний орлогоор эдийн засаг, нийгмийн хөгжлийн өсөлт, өөрчлөлтийн хандлагыг тооцдог байсан бол эдүгээ үндэсний орлогоос бүтцийн болон хамрах хүрээний хувьд нэлээд өргөн дотоодын нийт бүтээгдэхүүнийг тооцож байна.

Дотоодын нийт бүтээгдэхүүн нь аливаа улс орны эдийн засгийн хөгжлийн болон хүн амын амьжиргааны түвшинг илэрхийлэх гол үзүүлэлт юм. Тиймээс ч НҮБ-аас дэлхийн нийт улс орнуудад ДНБ-ийг нэгэн жишгээр тооцох зөвлөмж гаргасан бөгөөд хамгийн сүүлийн баримт бичиг нь 1993 онд НҮБ болон дэлхийн эдийн засгийн хамтын ажиллагааны 5 том байгууллагын хамтран баталсан "Үндэсний дансуудыг систем 93" аргачлал юм. Дэлхийн улс орнуудын дотоодын нийт бүтээгдэхүүнийг нэгэн жишгээр тооцсноор улс орнуудыг хооронд нь жиших, хөгжлийн түвшингээр нь зэрэгцүүлж үнэлгээ өгөх зэрэгт ач холбогдолтой юм.

ДНБ-ийг үйлдвэрлэлийн, хуваарилалтын, эцсийн ашиглалтын талаас нь 3 аргаар тооцдог ба ингэж 3 талаас нь тооцоход эцсийн дүндээ ойролцоо үр дүнд хүрч байх ёстой. Гэтэл үйлдвэрлэлийн болон эцсийн ашиглалтын аргаар тооцоход зөрүүтэй байдал гардаг. Энэхүү тооцооны зөрүүтэй байдал нь эдийн засагт далд эдийн засгийн нөлөөлөл байна гэх үндэслэлийг бий болгож байдаг.

Манай улс ДНБ-ний тооцооны арга зүйн хувьд "Үндэсний Тооцооны Систем-93" (ҮТС-93) аргачлалын дагуу тооцдог бөгөөд практикт үйлдвэрлэлийн болон эцсийн ашиглалтын аргаар тооцоог хийж байна. Ийнхүү нийт орлого болон нийт зарлагын талаас нь тооцсон тооцооноос үзвэл тооцооны хувьд зөрүүтэй гарч байгаа юм. Тэгэхээр манай улсын эдийн засагт далд эдийн засаг нэлээдгүй хувийг эзэлж байгааг харуулж байна. Тиймээс тооцооны зөрүүтэй байгаагийн учир шалтгааныг судлах, зөрүүг багасгах хэрэгтэй байна.

2. ДНБ-ний тухай, ДНБ-ний үйлдвэрлэлийн болон эцсийн ашиглалтын тооцооны зөрүүтэй байдал

Дотоодын нийт бүтээгдэхүүн нь Үндэсний Тооцооны Системийн хүрээнд чухал байр эзэлдэг эдийн засгийн үр дүнг илэрхийлэх нэгдмэл үзүүлэлт билээ. Олон улсын нийтлэг ойлголтоор бүтээгдэхүүн үйлдвэрлэх, үйлчилгээ үзүүлэхэд чиглэсэн нийгмийн бүхий л үйл ажиллагааг зах зээлийн ба зах зээлийн бус гэж ангилж үздэг бөгөөд эдгээр хүрээнд ашиг олох эс олохоос нь үл хамаарч салбарын түвшинд нэмэгдэл өртөг, макро түвшинд ДНБ-ийг тооцож, үйл ажиллагааных нь үр дүнг тооцдог. Энэ утгаараа ДНБ нь бүтээгдэхүүн, үйлчилгээний зах зээлийн борлуулалтын орлогоос завсрын хэрэглээ гэж нэрлэгддэг түүхий эд, үндсэн туслах материал, бусад биет болон үйлчилгээний зардлуудын өртгийг хассаны дараа үлдэх өртгийн хэмжээ юм.

Онолын хувьд ДНБ-ийг үйлдвэрлэлийн, хуваарилалтын, эцсийн ашиглалтын гэсэн 3 аргаар тооцдог бөгөөд үйлдвэрлэлийн болон хуваарилалтын аргаар тооцсноор тухайн жилд зах зээлийн болон зах зээлийн бус бүх үйлдвэрлэгчид ямар хэмжээний зардал гаргаж, хэдий хир орлого олов гэдгийг харах боломжтой болдог. Харин эцсийн ашиглалт нь үйлдвэрлэлийн аргаар тооцсон нэмэгдэл өртгийг зах зээлийн арилжаа солилцооны эцэст нийгмийн хэрэгцээнд хаана, ямар хэлбэрийн өртөг болгож ашиглав гэдгийг харуулдаг.

Энэ гурван аргын алианаар нь ч тооцсон ойролцоо үр дүнд хүрэх ёстой. Энэхүү аргууд нь аль нэг аргаар тооцсон дүнг давхар нотлох, шалгах үүрэгтэй зэрэгцээ судалгааны чухал ач холбогдолтой байдаг.

Энэ утгаараа ДНБ эцсийн ашиглалттайгаа тэнцэх ёстой юм. Гэтэл сүүлийн 8 жилийн тооцооноос харахад уг хоёр тооцоо зөрүүтэй гарсан байгаа нь харагдаж байна. Энэхүү тоон мэдээллийг хүснэгтээр харуулъя:

Хүснэгт : Эцсийн ашиглалтын аргаар болон үйлдвэрлэлийн аргаар тооцсон дотоодын нийт бүтээгдэхүүн.


	Абсолют утга (сая₮)							
	1995	1996	1997	1998	1999	2000	2001	2002
1. Эцсийн хэрэглээ (1.1+1.2+1.3)	421295.1	524620.6	617737.5	700796.8	790041.3	913220	1052153	1185452
1.1. ӨАА-н эцсийн хэрэглээ	348964.4	431658	503781.5	553303.8	631915.6	730006.7	834662.4	94879

1.2. УУБ-н эцсийн хэрэглээ	71397.4	91656.9	112048.1	144565.7	157128	180330	210537.9	228446.3
1.3. ОНБ-ын эцсийн хэрэглээ	933.3	1305.7	1907.9	2927.3	997.7	2883.3	6953.4	9212.5
2. Хуримтлал (2.1+2.2+2.3)	174492.4	193362.7	233555.2	288039.7	341400.3	368584.7	402208.6	410080.1
2.1. ҮХ-н хуримтлал	149149.8	181081.8	214947.4	274335	323448.3	321971.1	351594.1	360918
үүнээс: хөрөнгө оруулалт	91527	135250.9	180300	207956.1	258342.3	284733.5	309530.4	329270.2
2.2. МЭХ-н нөөцийн өөрчлөлт	25342.6	12280.9	15149.8	17655.7	17954	44396.2	45730.1	44277.7
2.3. ҮЗ-н нөөцийн өөрчлөлт			3458	-3951	998	2217.4	4884.4	4884.4
3. Бараа, үйлчилгээний экспорт, импортын зөрүү (3.1-3.2)	-6650.8	-51109.4	49829.9	110280.3	128847.6	170061.1	-211310	294575.8
3.1. Бараа, үйлч-ний экспорт	346109.1	262168.3	491338.1	451341.9	541978	660953.4	700370	761033.9
3.2. Бараа, үйлч-ний импорт	270759.9	313277.7	441508.3	562622.2	670825.6	831014.5	-911680	1055609.7
4. ДНБ (1+2+3) сая₮	589136.7	666873.9	901122.6	878556.2	1002594	6	3	1
5. ДНБ (үйлд-ийн аргаар, сая₮)	550253.7	646559.3	832635.6	817393.4	925345.8	1018885	1115641	1240786
6. Зөрүү (5-4) сая₮	-38883	-20314.6	-68486.9	-61162.8	-78248.2	-92858	127411.2	-60170.3

Эдийн засгийн онолын үүднээс хүн өөрт байгаа хөрөнгийн тодорхой хэсгийг хэрэглээд үлдсэн хэсгийг хадгалж, хуримтлал бий болгодог. Тиймээс нийт орлогын хэмжээ хэрэглээ, хуримтлалын дүнтэй тэнцэх ёстой байдаг.

Дээрх тоон мэдээллийг графикт дүрслэн харуулбал дараах байдалтай байна.

График : Эцсийн ашиглалтын болон үйлдвэрлэлийн аргаар тооцсон ДНБ.



Дээрх тооцооноос харахад дотоодын нийт бүтээгдэхүүнийг ашиглалтын талаас нь тооцсон тооцоо үйлдвэрлэлийн аргаар тооцсон тооцооноос илүү гарч байна.

Энэ нь нэг талаас орлогоос давсан зардал байгааг харуулж байгаа бөгөөд энэ зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг хэрхэн бүрдүүлж байна вэ? гэсэн асуултын хүрээнд манай улсын эдийн засагт далд эдийн засаг тодорхой хэмжээний байр суурь эзэлж байгаа гэх үндэслэлийг бий болгож байгаа юм.

Нөгөө талаас тодорхой хэмжээний эдийн засгийн үйл ажиллагаа явуулж байгаа зарим нэг үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчдийн бий болгож байгаа нэмэгдэл өртгийн хэмжээг бүрэн тусгаж тооцож чадахгүй байгаагаас дотоодын нийт бүтээгдэхүүний хэмжээ тэр хэмжээгээр буурч харагдаж байна.

Зөрүүтэй гарч байгаагийн гол шалтгаан нь уг тооцооны хамралт дутагдалтай байгаатай холбоотой бөгөөд тооцооны хамрагдалтыг сайжруулах явдал ихээхэн чухал байгаа билээ.

Бодит эдийн засаг зохицуулалттай болон далд эдийн засаг гэсэн хоёр хэсэгт хуваагддаг. Бодит эдийн засгийг тооцохдоо бид дотоодын нийт бүтээгдэхүүний хэмжээг ашигладаг. Тиймээс ямар ч эдийн засгийн үед дотоодын нийт бүтээгдэхүүн зэрэг нэгдмэл үзүүлэлтүүдийг тооцох шаардлага зүй ёсоор тавигдаж байгаа билээ. Харин энд нэг бэрхшээлтэй байгаа зүйл нь гэвэл далд эдийн засгийн хүрээнд бий болж байгаа нэмэгдэл өртгийн хэмжээг тооцох асуудал хүндрэлтэй байгаа юм.

Далд эдийн засагт:

- нуугдмал эдийн засаг
- хуурмаг эдийн засаг
- албан бус эдийн засаг
- өрхийн өөрийн эцсийн хэрэглээний үйлдвэрлэл гэсэн эдийн засгийн үйл ажиллагаа хамрагддаг. Эдгээр эдийн засгийн үйл ажиллагааны орлогын хэмжээг тооцож, дотоодын нийт бүтээгдэхүүний хэмжээнд тусгах хэрэгтэй байгаа юм.

Дотоодын нийт бүтээгдэхүүний тооцоонд дараах үйл ажиллагаа бүрэн хамрагдахгүй байна. Үүнд:

Холбогдох байгууллагаас албан ёсны зөвшөөрөл аваад зохих журмын дагуу үйл ажиллагаа явуулж байгаа хэдий ч бие даасан баланс гаргадаггүй аж ахуйн жижиг нэгжүүд, мөн албан ёсоор бүртгүүлж зөвшөөрөл аваагүй жижиг үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчдийн бүтээгдэхүүнийг бүрэн тооцож чадахгүй байна. Тухайлбал, ТҮЦ-үүд, лангуу эзэмшигчид, валют, түүхий эдийн ченжүүд, хүнс, барааны зах дээр болон гар дээрээс наймаа хийгчид, хувиараа тээвэр хийгчид, жижиг гар урчууд, мөрийтэй тоглоом эрхлэгчид, мэрэг төлөг үйлдэгчид, гутал тослох, засварлах үйлчилгээ эрхлэгчид, жижиг цайны газрууд, ном, сонингийн худалдаачид, тэрчлэн зарим хувийн хэвшлийн эмнэлэг, сургууль, ХЭАА, өрхийн аж ахуй зэргийн олон төрлийн үйлдвэрлэл, үйлчилгээ албан ёсны статистик мэдээлэлд хамрагдахгүй байна. Гэтэл ийм жижиг нэгжүүд эдийн засагт багагүй хувь эзэлдэг ба орлогыг нь тухай бүр тодорхойлох боломжгүй эдгээр жижиг аж ахуй нэгжүүдийг албан бус эдийн засагт хамруулдаг.

Эдгээрийн нэг онцлог нь үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчдийн зонхилох хэсэг нь үйл ажиллагаагаа ямар нэг хэлбэрээр нуух оролдлого хийгээгүй, харин тэдний үйл ажиллагааны үр дүнг мэдээлэлд хамруулж чадахгүй байгаад оршино. Мөн мэдээлэгчид статистикийн мэдээллийн ач холбогдлыг үл ойшоон ёс төдий хандах, төвөгшөөх, зарим нь бүр мэдээлэл өгөхөөс татгалзах зэргээс болж үйлдвэрлэлийн хэмжээг үнэн зөв тодорхойлоход багагүй бэрхшээл учруулж байна. Эдгээр жижиг хэмжээний үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчдийг эдийн засгийн албан бус секторт хамааруулж үздэг бөгөөд тэдгээрийн олж байгаа орлогын хэмжээг тооцон, нэгтгээд авч үзвэл манай улсын дотоодын нийт бүтээгдэхүүн нэлээд хэмжээгээр дутуу тооцогдож байна гэж үзэх үндэстэй.

Албан бус секторыг бий болгож байгаа жижиг хэмжээний үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчид татварын газраас үйл ажиллагаа явуулах зөвшөөрөл буюу патентын эрх авч үйл ажиллагаагаа явуулдаг. Гэвч тэдний орлогын хэмжээг тооцох асуудал нэлээд бэрхшээлтэй байгаа юм.

Жижиг бизнес эрхлэгчдийг эрхэлж байгаа үйл ажиллагааны 25 чиглэлээр ангилдаг бөгөөд нийслэлийн татварын газраас эдгээр ажил үйлчилгээ эрхлэгчдийн нийт тоог дүүргүүдээр авч нийт дүндээ дийлэнх буюу 37,1% эзэлж байгаа лангуугаар худалдаа хийгчдийг сонгон авч, зөвхөн ийм төрлийн бизнес эрхлэгчдийн үйл ажиллагаанаасаа олж буй орлогыг тодорхойлох зорилгоор түүвэрлэлтийн аргыг ашиглан тооцоо хийхэд дараах үр дүн гарлаа.

Нийт Улаанбаатар хотын хэмжээнд хувиараа жижиг бизнес эрхлэгч 19509 иргэд байдгаас 7244 буюу 37,13% нь лангуугаар худалдаа хийх, 7934 буюу 40,67% нь ТҮЦ-ээс худалдаа хийдэг иргэд байдаг бөгөөд судалгааны объектоо лангуугаар худалдаа эрхлэгч иргэдийг сонгон авлаа.

Нийслэлийн хэмжээнд нийт 9 дүүргээс 8 дүүргийн тоон мэдээг нийслэлийн татварын газраас авсан бөгөөд эдгээр дүүргүүдээс санамсаргүйгээр Баянгол дүүргийг сонгон авч $r=0.95$ магадлалтайгаар нийт 1413 лангуу эзэмшигчээс 71 объектийг сонгон авч орлогын талаарх судалгааг анкетын аргаар хийлээ.

$N=1413$ $n=71$

Судалгаанд 17-42 насны 71 хүмүүс хамрагдсан ба тэдний дундаж наслалт нь 27, нийт судалгаанд хамрагдагсдын 90,15 хувь нь эмэгтэйчүүд байлаа.

Лангууны эзэмшлийн хувьд ихэнх нь хамаатан болон хамаатан бус хүмүүсийг цалинжуулан ажиллуулдаг байна.

Нийт судалгаанд оролцогчдын орлого, зарлагын талаар асуулга бэлдэн мэдээлэл цуглуулж, судалгаа хийхэд хамгийн бага нь 7 хоногт дунджаар 10000 төгрөгний орлоготой гэсэн байхад хамгийн их нь 250-300 мөнгөн төгрөг гэсэн хариулт өгч байна. Судалгаанд хамрагсдын хариултаас харвал тухайн дэлгүүрийн байршил, худалдаж байгаа барааны төрөл гэх мэт маш олон шалтгааны улмаас орлогын хэмжээ харьцангуй болох нь харагдаж байлаа.

Эндээс судалгаанд хамрагсдын орлогын 7 хоногийн дундаж хэмжээг тооцож үзвэл 137229,17₮, стандарт хазайлт нь 110422,83₮ байгаа бөгөөд

сарын орлогын хэмжээ дунджаар 26806,34₮ <math>x<247652</math> -ын хооронд хэлбэлзэж байна гэсэн тооцоо гарч байна.

Сарын орлогын хэмжээг тооцохын тулд 7 хоногт олсон орлогыг 4-өөр үржүүлж гаргахад 548916,68 ₮ болж байна.

Эдгээр тооцооллоос сарын цэвэр ашгийн хэмжээг тооцож үзье.

Сард гаргасан (дундаж) зардлуудыг жагсаавал:

1. Түрээсийн зардал :	332428,57
2. Патентын зардал :	7264,7
3. Хоолны зардал :	37764=1258.8*30
4. Хоолноос бусад зардал :	74262,5
5. Цалингийн зардал:	81200
Нийт зардал:	532919,77
Сарын орлого :	548916,68
Цэвэр ашиг :	15996,91

Дээрх тооцооллоос сард дунджаар 532,9 мянган төгрөг зарлагаддаг гэсэн тооцоо гарч байхад орлогын хэмжээ 548,9 мянган төгрөг гэж гарч байна. Эндээс цэвэр ашгийн хэмжээг тооцоход сард 15996,91 төгрөг, жилд 191962,92 төгрөг гарч байна.

Түүврийн дунджийг ашиглан эх олонлогийн буюу Баянгол дүүргийн лангуу эзэмшигчдийн орлогын дунджийг тооцвол сард 22,6 сая төгрөг, жилд 271,2 сая төгрөг гэж гарч байна. Нийт хотын хэмжээгээр лангуу эзэмшигчдийн орлогыг түүвэр судалгааны үр дүнг ашиглан тооцвол сард 163714,4 сая төгрөг, 1964572,8 сая төгрөг гарч байна. Энэ тооцооллоос харахад албан бус секторын зөвхөн нэгээхэн хэсгийн орлогыг тооцоход багагүй орлого олдог нь илт байгаа бөгөөд эдгээр албан бусчуудын орлогын хэмжээг бүрэн тооцвол тэр хэмжээгээр ДНБ-ний хэмжээ өсөх нь ойлгомжтой юм.

3. Тооцооны зөрүүг багасгах

ДНБ-ний үйлдвэрлэлийн болон эцсийн ашиглалтын аргын тооцооны зөрүүтэй байдалд хамрах хүрээний дутагтай байдал, мэдээлэл өгөхгүй байх, буруу болон дутуу мэдээлэл зэрэг асуудлууд нөлөөлж байгаа бөгөөд эдгээр тооцооны зөрүүтэй байдлыг багасгах хэрэгтэй юм.

Үйлдвэрлэлийн аргаар тооцсон тооцооны хувьд юуны түрүүнд ДНБ-ний тооцооны хамралтыг сайжруулах, үүний тулд тооцооны гол объект болох аж ахуйн нэгж байгууллагуудын бүртгэлийг сайжруулах хэрэгтэй юм.

Аж ахуй нэгж байгууллагуудын бүртгэл татварын газрын мэдээлэлд тулгуурлагдан ҮСГ-ын Бизнес Регистрын санд хөтлөгдөж байдаг.

Өдөр бүр аж ахуй нэгж байгууллагууд шинээр байгуулагддаг, мөн татан буугддаг, үйл ажиллагаагаа түр болон бүрэн зогсоодог, дампуурдаг, нийлдэг гэх мэтийн үргэлж өөрчлөлтөд байдаг. Иймд Бизнес регистрийн сангийн мэдээлэлд энэ өөрчлөлтийг хамгийн түргэн хугацаанд, үнэн зөв хийх шаардлагатай юм. Аж ахуй нэгж байгууллагын эдгээр өөрчлөлтийг хийхдээ татварын хэлтсийн мэдээлэл дээр үндэслэн хийдэг. Энд нэг дутагдалтай тал нь ерөөсөө үйл ажиллагаа явуулахгүй байгаа зарим аж ахуй нэгжийг татварын газраас татан буулгадаггүй. Гэтэл эдгээр аж ахуй нэгж БРС-д

бүртгэлтэй байгаа учраас мэдээнд хамрагдаад байдаг. Гэтэл үйл ажиллагаа явуулахгүй байгаа аж ахуй нэгжээс мэдээ авах боломжгүй юм.

Эндээс ДНБ-ний хэмжээг тооцох тооцооны хамралтыг сайжруулахын тулд:

- Бизнес Регистрийн сангийн бүртгэлийн үйл ажиллагааг сайжруулах, үүний тулд аж ахуй нэгж байгууллагын бүртгэлийн тооллогыг шинээр хийж (нэг бүрчлэн бүртгээд) нэг мөр болгох
- Тооллогоо хийсний дараа түүн дээрээ гарсан өөрчлөлтийг тухай бүр нь бүртгэх (өөрөөр хэлбэл улирал тутам биш)
- Түүвэрлэлтийг үндэсний хэмжээнд биш тухайн орон нутагт нь бусдыгаа төлөөлж чадахүйц нэгжийг сонгон, мэдээгээ авах
- Мөн статистик мэдээллийн ач холбогдлыг нийтэд сайн сурталчилж, ойлгуулах хэрэгтэй юм.

ДНБ-ний хэмжээг эцсийн ашиглалтын талаас нь тооцохдоо

1. Эцсийн хэрэглээ. (C)
2. Нийт хуримтлал. (I)
3. Цэвэр экспорт. (X-M)
4. ДНБ (1+2+3) гэж тооцдог ба үйлдвэрлэлийн үйл явцад бий болгосон нэмэгдэл өртгийг нийгмийн хэрэгцээнд хэрхэн ашиглаж байна гэдгийг харуулдаг.

Ашиглалтын аргаар ДНБ-ийг тооцоход тооцооны аргачлалын хувьд олон улсад мөрдөж байгаа YTC-1993 аргачлалаас зөрүүтэй зүйл байхгүй ба энд дутагдалтай байгаа зүйл гэвэл мөн тооцооны хамралтын тал дээр байгаа юм.

1. Эцсийн хэрэглээний тооцооны хувьд өрх, хүн амын хэрэглээний мэдээллийг Өрхийн Аж Ахуйн орлого, зарлагын түүвэр судалгаа болон төсвийн орлого, зарлагын улирлын мэдээллээс авдаг.

Өрхийн аж ахуйн эцсийн хэрэглээний зардлыг тооцохдоо түүвэр судалгааны дүнг улсын хэмжээгээр тархаан тооцож байгаа нь хэрэглээний зарим барааг үнэн бодитой тооцоход бэрхшээлтэй байна. Иймд ОХУ зэрэг орны жишээгээр жижиглэнгийн бараа гүйлгээний статистик мэдээллийг бий болгох, ингэснээр хүн амын хэрэглээг бодитой тооцох боломжтой юм.

Улсын удирдлагын байгууллагын болон олон нийтийн байгууллагын хувьд хэрэглээний зардлын тооцоог бүрэн тооцож чаддаг гэж үздэг.

2. Нийт хуримтлалын хувьд мэдээллийг аж ахуй нэгж байгууллагын жилийн тайлан тэнцлээс авч болох бөгөөд мэдээллийн чанар, хамралтын тал дээр анхаарч ажиллах хэрэгтэй байгаа юм.

Энд:

Үндсэн хөрөнгийн хуримтлал нь эдийн засгийн бүх секторуудад тэдгээрийн тайлант жилд үйлдвэрлэсэн нэмэгдэл өртгийн зохих хэсгийн болон гадаад худалдааны балансын өөрчлөлтөөр бий болсон өртгөөр санхүүжиж, шинээр бий болсон барилга, байгууламж, тоног төхөөрөмж, тээвэр холбооны хэрэгсэл үндсэн сүргийн мал, олон наст ургамал, иргэдийн орон сууц, үнэт зүйлс зэрэг үйлдвэрлэлийн болон үйлдвэрлэлийн бус хэрэгцээнд удаан хугацаагаар ашиглагддаг хөрөнгийн өртөг юм.

Нийт хуримтлалыг тооцохдоо одоогоор хөрөнгө оруулалтын мэдээлэлд тулгуурлан тооцдог. Өөрөөр хэлбэл аж ахуй нэгжийн хөрөнгө оруулалт дээр материаллаг эргэлтийн хөрөнгийн болон үнэт зүйлсийн өөрчлөлтийг нэмж тооцдог. Эдгээрийг тооцохдоо тухайн тайлант оны эхний болон эцсийн үлдэгдлийн зөрүүгээр тооцох хэрэгтэй юм. Гэтэл энэ тооцоог оны эхний болон эцсийн үлдэгдлийн зөрүүгээр нь тооцохгүй байгаа нь дутагдалтай байгаа юм.

Хөрөнгө оруулалтыг санхүүжилтийн эх үүсвэрээр тооцоход банкны зээл, өөрийн хөрөнгө оруулалтын мэдээллийн хамралт хангалтгүй байдаг. Үүнийг тооцохдоо хувийн компаниудын өөрийн хөрөнгө оруулалтын мэдээллийг бүрэн цуглуулах, арилжааны банкуудаар хөрөнгө оруулалтын зориулалттай банкны зээлийн хэмжээг гаргуулах нь зүйтэй юм.

3. Цэвэр экспорт буюу экспорт, импортын зөрүүг тооцохдоо Монголбанкнаас гаргадаг төлбөрийн тэнцлийг ашигладаг.

Энэ тооцооны хувьд гарч байгаа дутагдалтай тал нь импортоор оруулж ирж байгаа ганзагын наймаачдын барааны өртгийг бүрэн тусгаж чадахгүй байгаа юм. Учир нь оруулж ирж байгаа барааны үнийн дүнд татвар оногдуулдаггүй өөрөөр хэлбэл ямар үнэтэй, хэдий хэмжээний бараа орж ирж байгааг бүртгэдэггүй, харин боодол тутамд татвар оногдуулж авдаг.

Эндээс ашиглалтын талаас нь тооцох аргын хувьд:

- Нийт хуримтлалын хэмжээг бодитой тооцох, үүний тулд оны эхний болон эцсийн байдлаар үндсэн хөрөнгө, материаллаг эргэлтийн хөрөнгө, үнэт зүйлсийн өөрчлөлтийн хэмжээг тооцож зөрүүгээр нь авах
- Бага хэмжээгээр орж ирж байгаа, өөрөөр хэлбэл ганзагаар орж байгаа импортын барааны өртгийг импортын дүнд бүрэн оруулж тооцох
- Үйлчилгээний экспорт, импортын мэдээллийг хамралтыг сайжруулах зэрэг арга хэмжээг авах хэрэгтэй.

Ашигласан материал.

1. "Үндэсний тооцооны систем" Б.Машир, Б.Батмөнх. Улаанбаатар 1995 он
2. "Үндэсний тооцооны данс, салбар хоорондын баланс" Г.Оросоо. Улаанбаатар 2002 он.
3. Монголын хүн амын сэтгүүл. 2003/9
4. "Далд эдийн засаг" Ү.Наранцэцэг. Улаанбаатар 2002 он.
5. "Статистикийн эмхэтгэл" Үндэсний статистикийн газар. Улаанбаатар. 1999, 2002 он.
6. <http://www.nso.mn>.
7. Нийслэлийн татварын газрын холбогдох мэдээлэл. 2003 он.
8. Монгол улсын татварын тухай багц хууль. "Орлогыг нь тухай бүр тодорхойлох боломжгүй ажил, үйлчилгээ эрхлэгч иргэний орлогын албан татварын тухай" 71-76 хуудас. 2002 он. УБ.
10. "Statistics for business and economics" Third edition. David.R.Anderson, Dennis J. Sweeney, Thomas A. Williams